



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 5/МЗ

Хэрлэн сум

Ч.Баярцолмонг шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 2.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2024 оны “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай” 82 дугаар тогтоолын хавсралт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын 4.1.8, 2.6.8 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арван наймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн дарга Чимэдбатын Баярцолмонг ажлын шаардлагаар 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн Хууль эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт, сурталчилгаа, хүний эрх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр шилжүүлэн томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Д.Мягмарбаатар Хууль, эрх зүйн хэлтсийн даргын

2.

Гишүүд:

Ш.Эрдэнэжаргал

үүргийг түр орлон гүйцэтгэгч

Хүний нөөц, дотоод ажил, агентлаг
хариуцсан мэргэжилтэн

Т.Баяртуяа

Нярав

3.Ч.Баярцолмонгийн цалинг ТЗ-7 зэрэглэлээр тогтоон, үндсэн цалинг 1,452,000 (нэг сая дөрвөн зуун тавин хоёр мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 19 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг 30 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4.Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэн, холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллахыг Ч.Баярцолмонд үүрэг болгосугай.

5.Ч.Баярцолмонгийн ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлж, холбогдох эд хөрөнгийг бүртгэлжүүлэн авахыг комиссын бүрэлдэхүүн (Д.Мягмарбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА